



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,

И мэйл: ub@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

2025. 02. 25

№

01/277

танай

-ны №

-т

「
НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ж.ЛХАГВАСҮРЭН ТАНАА

Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг хүргүүлж байна.

Аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлэхийг зөвлөж байна.

Хавсралт 30. хуудастай.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР
М.ЭРДЭНЭЖАРГАЛ

02024287



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.02.25 № 01/268
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ж.ЛХАГВАСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газар нь Засаг даргын нөөц хөрөнгийн төсвийг 1,565.0 сая төгрөгөөр баталж, 1,323.7 сая төгрөгийг зарцуулсан нь өмнөх оноос 2.1 дахин өссөн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд байгууллагын үйл ажиллагааны зардалд 13,714.7 сая төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд 2 удаа тодотгол хийж, 37.4 хувиар нэмэгдүүлж, нийт 18,837.9 сая төгрөгөөр баталжээ. Үйл ажиллагаандаа 16,687.5 сая төгрөгийн төсөв зарцуулсан нь өмнөх онтой харьцуулахад 39.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Бусад асуудал

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 59 зорилтын хүрээнд 133 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90.7 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна. Тайлант онд 30 хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулан 202.8 сая төгрөгийн зардлыг үйл ажиллагааг сурталчлан таниулахад зарцуулжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 245/А0260171

Улаанбаатар хот

НТАГ- 2025/602/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэг ижил төрлийн бараа, ажил үйлчилгээ худалдан авалт хийхдээ тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийж төсөвт өртгийг хувааж 503,082,300.00 (таван зуун гурван сая наян хоёр мянга гурван зуун) төгрөгийн гэрээг шууд байгуулсан, газар чөлөөлөх 225,614,700.00 (хоёр зуун хорин тавин мянга зургаан зуун арван дөрвөн мянга долоон зуун) төгрөгийн ажилд сонгон шалгаруулалт зарлалгүйгээр 6 компанитай шууд гэрээ байгуулж ажил, үйлчилгээ авсан, үр дүнг үнэлж, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй зэрэг хангалтгүй баримтаар нийт 728,697,000.00 (долоон зуун хорин найман мянга зургаан зуун ерэн долоон мянган) төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 10 дугаар зүйлийн 10.3-д "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Лхагвасүрэн, нягтлан бодогч Г.Гадинжид нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨНІ:

АХЛАХ АУДИТОР

Н.БАТТОГОО

ХЯНАСАН:

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Я.АЛТАНЦЭЦЭГ

1. Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

1117145635
УХА0612 9077278

1425040152



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 дугаар сарын 25

№ 65/402601Н

Улаанбаатар хот

НТАГ- 2025/602/НА-СТА-Тш3

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Нягтлан бодогчийн ажлыг хавсран хийж байсан албан тушаалтанд ажлаас гарсны тэтгэмж, урамшуулалд 6,684,000.00 (зургаан сая зургаан зуун наян дөрвөн мянга) төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Илүү олгосон урамшууллын 6,684,000.00 (зургаан сая зургаан зуун наян дөрвөн мянга) төгрөгийг Нийслэл дэх Төрийн аудитын газрын төрийн сан банкин дахь НТАГ.хүү орлогын 100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 31-ний дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Лхагвасүрэн, нягтлан бодогч Г.Гадинжид нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН¹:

АХЛАХ АУДИТОР



Н.БАТТОГОО

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Я.АЛТАНЦЭЦЭГ

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

1425050066



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2025 оны 02 дугаар сарын 25

№ 66/А0260171

Улаанбаатар хот

НТАГ-2025/602/НА-СТА-ТШЗ.

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Арга хэмжээний зардалд 2,390,000.00 (хоёр сая гурван зуун ерэн мянга) төгрөгийн шатахуун тослох материал тооцож олгосон боловч жолоочийн замын хуудас, зарцуулсан нотлох баримтгүй зарлага гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4. "үнэн зөв байх," 13 дугаар зүйлийн 13.7 "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8. "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Анхан шатны нотлох баримтгүй олгосон 2,390,000.00 (хоёр сая гурван зуун ерэн мянган) төгрөгийг Нийслэл дэх Төрийн аудитын газрын төрийн сан банкин дахь НТАГ.хүү орлогын 100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 31-ний дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Лхагвасүрэн, нягтлан бодогч Г.Гадинжид нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН1:

АХЛАХ АУДИТОР

ХЯНАСАН:

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Н.БАТТОГОО

Я.АЛТАНЦЭЦЭГ

1117145633
УХА0612 9077278

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

1425050055